



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА

### ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,  
Сайнцагаан сум, Нарлаг баг  
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08  
E-mail: dundgovi@audit.gov.mn

2017.02.15 № 01/21

ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Л.МОНХБАДРАХ ТАНАА

#### Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-т заасан бурэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Өндөршил сумын тусгай зориулалтын сангүүгийн аudit хийх явцад 115,788,390.00 /Нэг зуун арван таван сая долоон зуун наян найм гурван зуун ерэн/ төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20.2.6-д /Бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах/ заасныг зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дурмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.4-т /Байгууллага, иргэдтэй ууссан материаллаг дүйтэй буюу насхилт өндөртэй авлага, өглөгийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, насхилтын тайлан гаргах, зөрчлийг давтан гаргахгүй байх;
2. Хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бууруулах, хууль, хяналтын байгууллагад хандаж шийдвэрлүүлэх;

000000042

3. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2017 оны 03 дугаар сарын 05-ны дотор аймгийн Аудитын газарт ирүүлэхийг Өндөршил сумын Засаг дарга Л.Мөнхбадрах, нягтлан бодогч Б.Сайхантуяа нарт даалгав.

### АЛБАН ШААРДЛАГЫГ



<sup>1</sup> Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанд ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ/